



**ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Зарим албан хаагчдын ажлын  
цагийн горимыг өөрчлөх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дахь заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг дуустал тус газрын 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй албан хаагчдыг гэрээсээ ажиллах нөхцлөөр хангаж, ажлын цагийн тусгай горимд шилжүүлсүгэй.

2. 0-12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн нэрс болон ажлын цагийг хавсралтаар баталсугай.

3. Ажлын цагийн тусгай горимд шилжсэн албан хаагчид Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамны шийдвэр зөвлөмжийг дагаж мөрдөх, албан үүргээ бүрэн гүйцэтгэж байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй ажлаа зохион байгуулахыг үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга / С.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР

000281

Д/д	Хэлтэс, нэгж	Албан тушаал	Овог, нэр	Ажиллах цаг
1.	Аж үйлдвэрийн өмчийн хэлтэс	Шинэ бүтээл, ашигтай загварын шинжээч	Б.Одгэрэл	Цахимаар гэрээсээ ажиллах
2.	Аж үйлдвэрийн өмчийн хэлтэс	Барааны тэмдгийн шинжээч	Г.Буяндэлгэр	Цахимаар гэрээсээ ажиллах
3.	Зохиогчийн эрхийн хэлтэс	Мэргэжилтэн шинжээч	Г.Ууганцэцэг	Цахимаар гэрээсээ ажиллах
4.	Аж үйлдвэрийн өмчийн хэлтэс	Барааны тэмдгийн шинжээч	Б.Оюунцэцэн	Цахимаар гэрээсээ ажиллах
5.	Аж үйлдвэрийн өмчийн хэлтэс	Бүтээгдэхүүний загварын шинжээч	О.Оюунгэрэл	Цахимаар гэрээсээ ажиллах
6.	Аж үйлдвэрийн өмчийн хэлтэс	Бүртгэлийн мэргэжилтэн	С.Нандинцэцэг	8.30-14.30
7.	Зохиогчийн эрхийн хэлтэс	Мэргэжилтэн шинжээч	Б.Хэрлэнчимэг	8.30-14.30
8.	Захиргаа удирдлагын хэлтэс	Мэдээлэл технологийн мэргэжилтэн	Б.Шүр-Эрдэнэ	8.30-14.30
9.	Захиргаа удирдлагын хэлтэс	Эрх зүй хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	С.Цоггэрэл	8.30-14.30